“МЭДЭЭЛЭЛ-АУДИТ” ХХК

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## “МИЛЛЕННИУМ ФИНАНС” ББСБ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлан

**Улаанбаатар хот**

**2025 он**

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК

2025.02.25 № 03

танай_____ -ны №_____-т

"Милленниум финанс"ББСБ -ийн
УДИРДЛАГА БОЛОН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛ-д

***Хараат бус аудиторын тайлан***

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Бид **Милленниум финанс ББСБ** *(цаашид "Компани" гэх)-ийн* 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

***Дүгнэлтийн үндэслэл***

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "*Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага"* хэсэгт харуулав. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулийн эдгээр шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид найдаж байна.

***Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдүүдийн хүлээх хариуцлага***

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

***Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага***

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18-р хороо,
Скай апартмент, 32-в байр, 19 тоот
Утас: (976) 70159511
И-мэйл: medeelelaudit@gmail.com

болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглаж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн таамаглал болон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь ул үндэслэлтэй эсэхийг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг авч үздэг. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж үзвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдэд мэдэгддэг.

Санхүүгийн тайлангийн аудитын үед аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг ММНБИ-ийн monicpa.mn сайтад байрлах манай аудитын компанийн холбоосонд байрлуулсан бөгөөд энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл нь бидний аудиторын тайлангийн хэсэг болно.

***Тайлангийн хэрэглээ***

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу **Милленниум финанс ББСБ**-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**ЗАХИРАЛ, МНБ** **Д.ТОВУУДОРЖ**

# АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

*/ төгрөг/*

| Үзүүлэлт | Тод руулга | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 3 | 58,311,486.94 | 101,930,741.01 |
| Зээл | 4 | 1,797,833,133.22 | 2,154,771,654.77 |
| Факторингийн тооцооны авлага | 5 | | |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | 6.1 | | |
| Хөрөнгө оруулалт | 7 | | |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 8 | 676,091,493.71 | 22,726,437.48 |
| **Санхүүгийн хөрөнгийн дүн** | | 2,532,236,113.87 | 2,279,428,833.32 |
| Татвар, НДШ-ийн авлага | 9 | | |
| Үндсэн хөрөнгө | 10 | 92,529,237.54 | 92,529,237.54 |
| Биет бус хөрөнгө | 11 | 82,824,313.50 | 82,824,313.50 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | | |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 12 | | 160,798,462.10 |
| **Санхүүгийн бус хөрөнгийн дүн** | | 175,353,551.04 | 336,152,013.14 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **2,707,589,664.91** | **2,615,580,846.46** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр | 13 | | |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 14 | | |
| Бусад эх үүсвэр | 15 | | |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | 6.2 | | |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 16 | | |
| Хоёрдогч өглөг | 17 | | |
| Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) | | | |
| **Санхүүгийн өр төлбөрийн дүн** | | | |
| Татвар, НДШ-ийн өр төлбөр | 18 | 9,303,607.36 | 14,393,345.98 |
| Нөөц /Болзошгүй өр төлбөр / | 19 | | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | | | |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 19 | 19,500,000.00 | |
| **Санхүүгийн бус өр төлбөрийн дүн** | | 28,803,607.36 | 14,393,345.98 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | 28,803,607.36 | 14,393,345.98 |
| **ӨМЧ** | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 20 | 2,652,000,000.00 | 2,652,000,000.00 |
| Өмчийн бусад хэсэг | | | |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | | 26,786,057.55 | -50,812,499.52 |
| **НИЙТ ӨМЧИЙН ДҮН** | | 2,678,786,057.55 | 2,601,187,500.48 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | | **2,707,589,664.91** | **2,615,580,846.46** |

Мэдээлэл Аудит ХХК РД. 2703939

# АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

*/төгрөг/*

| д/д | Орлого, зардлын зүйл | Тодруулга | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|---|
| **1** | **Хүүгийн орлого** | | 201,547,553.25 | 134,970,221.34 |
| 1.1 | Банканд байршуулсан хөрөнгийн | | | |
| 1.2 | Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | | | |
| 1.3 | Зээлийн хүүгий орлого | | 201,547,553.25 | 134,970,221.34 |
| 1.4 | Үнэт цаасны | | | |
| 1.5 | Бусад | | | |
| 1.6 | Хүүгийн орлогын буцаалт | | | |
| **1.7** | **Хүүгийн орлогын дүн** | | **201,547,553.25** | **134,970,221.34** |
| **2** | **Хүүгийн зардал** | | | |
| 2.1 | Итгэлцлийн үр шим | | | |
| 2.2 | Зээлийн хүүгийн зардал | | | |
| 2.3 | Үнэт цаасны | | | |
| 2.4 | Бусад | | | |
| 2.5 | Хүүгийн зардлын буцаалт | | | |
| **2.6** | **Хүүгийн зардлын дүн** | | **0.00** | **0.00** |
| **3** | **Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)** | | 201,547,553.25 | 134,970,221.34 |
| **4** | **Эрсдэлийн сангийн зардал** | 21 | 16,976,083.92 | |
| **5** | **Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)** | | 184,571,469.63 | 134,970,221.34 |
| **6** | **Бусад орлого** | | **130,000.00** | **1,895,303.59** |
| 6.1 | Хүүгийн бус орлого | 22 | 130,000.00 | 1,895,303.59 |
| 6.2 | Бусад орлого, олз | 23 | | |
| **7** | **Бусад зардал** | | **234,987,749.70** | **213,998,082.00** |
| 7.1 | Хүүгийн бус зардал | 24 | 228413106..70 | 190,237,002.00 |
| 7.2 | Бусад зардал, гарз | 25 | 6,574,643.00 | 23,761,080.00 |
| **8** | **Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)** | | -50,286,280.07 | -77,132,557.07 |
| 9 | Орлогын татварын зардал | | | |
| **10** | **Татварын дараах ашиг, алдагдал (8-9)** | | -50,286,280.07 | -77,132,557.07 |
| **11** | **Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал** | | | |
| **12** | **Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)** | | -50,286,280.07 | -77,132,557.07 |
| **13** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | | |
| **14** | **Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)** | | -50,286,280.07 | -77,132,557.07 |

Мэдээлэл Аудит ХХК РД. 2703939

## АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*/төгрөг /*

| Өөрийн хөрөнгийн зүйл | Хувь нийлүүлсэн хөрөнгө | Хуримт-лагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31 -ээр үлдэгдэл** | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 2,652,000,000.00 | 77,072,337.92 | 2,729,072,337.92 |
| Залруулсан үлдэгдэл | 2,652,000,000.00 | 77,072,337.92 | 2,729,072,337.92 |
| Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал | | -50,286,280.37 | -50,286,280.37 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | |
| Хуваарилсан ногдол ашиг | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | |
| **2023 оны 12-р сарын 31 -ээр үлдэгдэл** | **2,652,000,000.00** | **26,786,057.55** | **2,678,786,057.55** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | 466,000.00 | 466,000.00 |
| Залруулсан үлдэгдэл | 2,652,000,000.00 | 26,320,057.55 | 2,678,320,057.55 |
| Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал | | -77,132,557.07 | -77,132,557.07 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | 0.00 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | 0.00 |
| Хуваарилсан ногдол ашиг | | | 0.00 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | 0.00 |
| **2024 оны 12-р сарын 31 -ээр үлдэгдэл** | **2,652,000,000.00** | **-50,812,499.52** | **2,601,187,500.48** |

Мэдээлэл Аудит ХХК РД: 2703939

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*/төгрөг/*

| д/д | Үзүүлэлт | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| **1** | **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1.1 | Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан | 604,532,043.25 | 465,700,907.93 |
| 1.5 | Бусад | 236,286,642.51 | 3,881,030.00 |
| **1.6** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **840,818,685.76** | **469,581,937.93** |
| 1.7 | Олгосон зээл | 418,500,000.00 | 188,833,735.54 |
| 1.11 | Ажиллагсдад олгосон | 127,592,516.73 | 112,429,748.85 |
| 1.12 | Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 15,923,512.87 | 49,413,242.15 |
| 1.13 | Ашиглалтын зардалд төлсөн | 41,668,600.00 | 28,201,268.00 |
| 1.14 | Бусад | 410,446,309.48 | 37,084,689.26 |
| **1.15** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | 1,014,130,939.08 | 415,962,683.80 |
| **1.16** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-173,312,253.32** | **53,619,254.13** |
| **2** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 2.1 | Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан | | |
| 2.2 | Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан | | |
| 2.3 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан | | |
| 2.4 | Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан | | |
| 2.5 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **2.6** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого** | | |
| 2.7 | Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.8 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.9 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.10 | Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.11 | Бусад | | |
| **2.12** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага** | | |
| **2.13** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | | |
| **3** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 3.1 | Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан | | |
| 3.2 | Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан | | |
| 3.3 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.4 | Бусад | | |
| **3.5** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого** | | |
| 3.6 | Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн | | |
| 3.7 | Хоёрдогч өглөгт төлсөн | | |
| 3.8 | Төлсөн ногдол ашиг | | 10,000,000.00 |
| 3.9 | Бусад | 6,574,643.00 | |
| **3.10** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | 6,574,643.00 | 10,000,000.00 |
| **3.11** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-6,574,643.00** | **-10,000,000.00** |
| **4** | Валютын ханшийн зөрүү | | |
| **5** | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -179,886,896.32 | 43,619,254.13 |
| **6** | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | **58,311,486.94** |
| **7** | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **58,311,486.94** | **101,930,741.07** |
| 1 | БЦМГ/1.16+2.13+3.11/ | **-179,886,896.32** | **43,619,254.13** |
| 2 | БЦМГ /7-6/ | **58,311,486.94** | **43,619,254.13** |
| 3 | Зарүү | **238,198,383.26** | |

Шэдэлэл Аудит ХХК РД: 2703939

## ""Милленниум финанс" ББСБ ба түүний үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл

"Милленниум финанс" ББСБ Хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид –"Компани" гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/226/528 дугаар тушаалаар батлагдсан "ББСБ-ын санхүүгийн тайлангийн маягт, тодруулга"-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

### Үндсэн үйл ажиллагаа .

***Үндсэн үйл ажиллагаа:*** "Милленниум финанс" ББСБ нь Улсын бүртгэлийн 9015002008, регистрийн 5297498 тоот дугаартай, 810,000.00 мянган төгрөгийн эздийн өмчтэй, 1 гишүнтэйгээр байгуулагдсан. 2022 оны 04 сарын 04 өдөр өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж 2,652,000 мянган төгрөг болон нэмэгдүүлж улсын бүртгэлийн гэрчилгэндээ өөрчлөлт оруулсан.
2016 онд "Зээл" чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан.
**Бүртгэлтэй хаяг**. Милленниум финанс ББСБ" ХХК-ийн албан ёсны хаяг:Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, ЧӨЧ17, Гэрэгэ тауэр 701 тоотод байрлаж байна.
**Бүртгэлийн *валют*** . *Эдгээр санхүүгийн тайлангийн хүснэгтийг өөрөөр заагаагүй бол төгрөгөөр ("төгрөг") үзүүлэв.*

### Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

**Тайлан бэлтгэх үндэслэл:** Эдгээр санхүүгийн тайлангуудыг бодит үнэ цэнэд суурилсан санхүүгийн хэрэглүүрийг анхны хүлээн зөвшөөрөх, мөн бодит үнэ цэнээр ангилсан санхүүгийн хэрэгслийг дахин үнэлэх замаар өөрчилсөн түүхэн өртгийн зарчимд үндэслэн Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын (СТОУС ) дагуу бэлтгэгдсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг доор харуулав. Эдгээр бодлогуудыг өөрөөр заагаагүй бол толиллуулсан бүх хугацаанд тууштай мөрдсөн болно.

**Тасралтгүй байх зарчим.** Компани 2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд 77.1 сая төгрөг (2023 онд 55.3 сая)-ийн алдагдалтай байгаа нь компанийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх чадавхид эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхойгүй байдал оршин байгааг харуулж байна.
Иймд, хэрэв нэмэлт санхүүжилт хийгдэх боломжгүй эсвэл тасралтгүй байх зарчмаар үйл ажиллагаа үргэлжлэх боломжгүй тохиолдолд үүсч болох хөрөнгө болон өглөгийн ангилал, хэмжээтэй холбоотой аливаа залруулгыг энэхүү санхүүгийн тайланд тусгаагүй болно.

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.** Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой, богино хугацаат өндөр хөрвөх чадвартай хөрөнгө юм. Мөнгөн хөрөнгөд касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө багтана. Монголбанк болон Засгийн газраас бусад этгээдийн гаргасан бонд, вексель зэрэг үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын эрсдэл тодорхойгүй тул мөнгө ба мөнгөтэй адилтгах зүйл гэж үзэхгүй. Ийм төрлийн хөрөнгө оруулалтыг 90 хоногоос богино хугацаатай байсан ч хөрөнгө оруулалтаар бүртгэнэ. Үүний нэгэн адил үнэ цэнийн бууралтын эрсдэлтэй, эсхүл мөнгөн хөрөнгийг хязгаарласан бөгөөд шууд зарцуулах боломжгүй тохиолдолд банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөөр бүртгэнэ. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, анх гаргасан хугацаанаас хойш 3 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бусад хөрөнгө хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь бүртгэх ба тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Мэдээлэл Аудит ХХК РД: 2703939

Энэ хөрөнгөтэй холбоотой хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дүнд оруулж, санхүүгийн тайланд толилуулна. Хугацаа хэтэрсэн буюу үнэ цэнэ буурсан санхүүгийн хэрэгсэл нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тодорхойлолтод нийцэхгүй тул холбогдох ангилалд шилжүүлэн бүртгэх ба хөрөнгийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хэрэгсэлд эрсдэлийн сан байгуулна.

**Хөрөнгө оруулалт:** Хөрөнгө оруулалтад 3 сараас дээш хугацаатай Монголбанкны болон Засгийн газрын үнэт цаас, мөнгөтэй адилтгах хөрөнгийн тодорхойлолтод багтаагүй бусад өрийн үнэт цаас, арилжааны зориулалттай, эсхүл борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт хамрагдах ба эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн бүртгэнэ. Хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс байгуулсан эрсдэлийн санг хасаж, хуримтлуулан тооцсон хүүгийн авлагыг нэмсэн дүнгээр толилуулна. Хөрөнгө оруулалтыг хадгаламжийн сертификат, үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэж хоёр ангилна

**ЗЭЭЛ** Зээл гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр бусад этгээдэд хүүтэй буюу хүүгүй олгосон мөнгөн хөрөнгийг ойлгоно. Зээлийг зээлийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна. Зээлийн хугацаа дуусан, зээлдэгч гэрээнд заасан төлбөрөө барагдуулж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн, эсхүл гэрээгээр үүссэн эрхээ бусдад бүрэн шилжүүлсэн тохиолдолд зээлийг данснаас хасаж бүртгэнэ. Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ба хэрэв зээл олгохтой шууд холбоотой ажил гүйлгээний зардал гарсан бол уг зардлыг бодит үнэ цэнэ дүн дээр нэмэх эсвэл хасах байдлаар хэмжинэ. Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна. Зээлдэгч тал үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хойшлуулан бүртгэж, холбогдох эх үүсвэрийн дүнг бууруулна. Үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хоёр төрөлд ангилж болно:

1.зээл олгохтой холбоотой шимтгэл, хураамж (зээл олголтын хураамж)

2.хэлцэлд заасан үүрэгтэй холбоотой шимтгэл, хураамж (хүлээсэн үүргийн хураамж).

Зээл олголтын хураамж нь дараах зүйлсээс бүрдэнэ:

1.Зээлдэгчийн "урьдчилж төлсөн" хүү эсхүл зээлийн нэрлэсэн хүүгийн түвшнийг бууруулах хураамж, шимтгэл буюу зээлдэгчийн санхүүгийн байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа хөрөнгө, бусад хэлцлийг үнэлж, гэрчлэх, нөхцөлийг харилцан зөвшилцөх, баримт боловсруулах зэрэг үйл ажиллагаатай холбоотой бол шимтгэл, хураамжийг зээл олголттой холбоотой гэж үзнэ.

2.Зээл олгох үйл ажиллагаанд шууд хамаарах бусад шимтгэл, хураамж (зээл олгосны шагналд төлсөн эсхүл хурдан хугацаанд зээл гаргахад зориулан зээлдэгчид төлсөн шимтгэл, хураамж). Зээлийн шимтгэлийг хэрхэн бүртгэх нь зээл олгогдох магадлалтай эсэх болон зээлд хамаарах үүрэг нь СТОУС 9-ийн хүрээнд багтсан эсэхээс шалтгаалан тодорхойлогдоно. Хэрэв зээл олгогдох магадлалтай бөгөөд зээлд хамаарах үүрэг нь СТОУС 9-ийн хамрах хүрээнд багтаагүй тохиолдолд шимтгэлийг санхүүгийн хэрэгсэлд зориулагдсан төлбөр гэж үзэх тул хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар тохируулна. Хэрэв зээл олгогдоогүй тохиолдолд шимтгэлийг шийдвэр гарсан өдрөөр зээлдүүлэгч нь орлогод бүртгэнэ. Зээлийн шугамыг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн ашиглах магадлалтай гэх нотолгоо байгаа бол шимтгэлийг СТОУС 9-д заасны дагуу хойшлуулан бүртгэнэ. Энэ тохиолдолд шимтгэлийг зээл олгох хүртэл хорогдуулж бүртгэхгүй. Зээлийн шугамыг нээж, үүнээс зөвхөн тодорхой хэсгийг ашиглаж, зээл олгосон бол нийт төлсөн хураамжийн жигнэсэн хэсэг нь харгалзах ажил гүйлгээний өртөг болох тул үүнийг зээл олгогдох хүртэл хойшлуулан бүртгэнэ. Зээлийн шугамыг ашиглах магадлалтай гэх нотолгоо байхгүй бол шимтгэл нь зээлийн шугамыг нээх төлбөр болох ба үүнийг хойшлуулан бүртгэж, зээлийн шугамын хүчинтэй байх хугацаанд хорогдуулна.

**Зээлийн эрсдэлийн сан (үнэ цэнийн бууралт)** ТЗЭ нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу сар бүр зээлийн эрсдэлийн санг байгуулна. Түүнчлэн тайлант жилийн эцэст зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС-9-д нийцүүлэн тооцож болно. СТОУС 9-д заасан үнэ

Мэдээлэл Аудит ХХК РД. 2703939

цэнийн бууралтын загвар нь хүлээгдэж буй алдагдлын загвар бөгөөд алдагдал үүсэх үйл явдал тохиолдохоос өмнө үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг. Иймд ТЗЭ нь зээлийн үнэ цэнийн бууралтыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнгээр үнэлж, бүртгэнэ.

**Санхүүгийн түрээс** Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор эрх олгосон тохиолдолд ТЗЭ нь санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг эрхэлж болно. Санхүүгийн түрээсийг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ СТОУС 16-г дагаж мөрдөнө.

**Бусад санхүүгийн хөрөнгө** Бусад санхүүгийн хөрөнгө гэж бусад аж ахуйн нэгжээс мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрхийг хэлнэ. Хэрэв мөнгө болон санхүүгийн бусад хөрөнгийг авах гэрээний эрх үүсээгүй тохиолдолд уг хөрөнгийг бусад санхүүгийн бус хөрөнгө гэж үзнэ. Зээлээс бусад тооцооны авлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага, салбар хоорондын тооцоо, өмчлөх бусад хөрөнгө (зээлдэгчээс зээлийн төлбөрт авсан үнэт цаас гэх мэт санхүүгийн хөрөнгө), бусад санхүүгийн хөрөнгийг хамруулна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага, санхүүгийн хөрөнгө хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын "Хөрөнгө оруулалт" бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ. Авлагыг эрсдэлийн санг хассан цэвэр дүнтэй тэнцэх хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Гадаад валютаар төлөгдөх авлагыг Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар хүлээн зөвшөөрнө. Иргэн, хуулийн этгээд тус бүрээр нэрийн данс нээж хөтөлнө. Авлагын дансны үлдэгдэл нь түр хугацааны шинж чанартай бөгөөд эцсийн тооцоо хийгдэхэд хаагдана.

**Санхүүгийн бус хөрөнгө** Санхүүгийн бус хөрөнгө гэж үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн бус хөрөнгөд урьдчилж төлсөн зардал, тооцоо, бараа материал, үнэ бүхий зүйлс, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, тайлант үеийн татварын авлага, хойшлогдсон татварын хөрөнгө, өмчлөх бусад хөрөнгө (хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө), үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө зэрэг хамаарна. Татвар, НДШ-ийн авлагыг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнгээр бүртгэнэ. Тайлагналын өдрөөр татварын төрлөөр авлага, өглөгийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тайлагнана. Тайлант хугацааны татварын илүү төлөлт (авлага) болон хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжих талаар энэ журмын "Орлогын албан татвар" бүлгээс үзнэ үү. Урьдчилгаа нь урьдчилж төлсөн зардал болон урьдчилж төлсөн тооцооноос бүрдэнэ. Урьдчилгааг төлсөн мөнгөн дүнгээр хэмжинэ. Хөрөнгийг худалдан авч, олж бэлтгэхтэй холбоотой урьдчилгаа төлбөр болон томилолтын зардлыг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэнэ. Хөрөнгийг хүлээж авсан, томилолтын тооцоог хийсэн үед урьдчилгаа тооцоог хааж, холбогдох хөрөнгө эсхүл зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

**Үндсэн хөрөнгө** Үндсэн хөрөнгө гэж бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслэх эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа, нэг жилээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй, биет хөрөнгө юм. Үндсэн хөрөнгийг нийтлэг шинж чанар, зориулалтаар нь барилга байгууламж, компьютер дагалдах хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө гэж ангилна. Хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд худалдан борлуулах зориулалтгүй хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь хөнгөлөлт ба үнийн бууралтыг хассан үнэ, импортын татвар ба бүцаан үл олгогдох худалдан авалтын татвар, хөрөнгийг ашиглах боломжтой байршил болон нөхцөл байдалд авчрахтай шууд хамааралтай зардал, үндсэн хөрөнгийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах тооцоолсон зардал зэргээс бүрдэнэ. Үндсэн хөрөнгийг өртгийн загвар ба дахин үнэлгээний загварын аль нэгээр бүртгэнэ. Өртгийн загвар нь хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулна. Дахин үнэлгээний загвар нь хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

Мэдээлэл Аудит ХХК РД 2703939

**Биет бус хөрөнгө** гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус зүйлсийн хөрөнгө юм. Нэгээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах, биет шинж чанаргүй программ хангамж, гүүдвил болон бусад биет бус хөрөнгүүд хамаарна.

**Бусад санхүүгийн өр төлбөр** гэж үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй өр төлбөр буюу ихэнхдээ бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр хүлээсэн гэрээний үүргийг ойлгоно. Санхүүгийн хөрөнгийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг НББОУС заасан бөгөөд нийтлэг тохиолдол, нөхцөл байдлыг энэ зааврын дагуу өр төлбөрийн ангиллыг тогтоох боломжгүй тохиолдолд уг стандартыг ашиглана. Бусад санхүүгийн өр төлбөрт хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг, бусдад өгөх өглөг, салбар хоорондын тооцоо, мөнгөн гуйвуулгын өглөг, цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг, ногдол ашгийн өглөг, мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион, хөрвөх өр төлбөр хамрагдана. Мөнгөн гуйвуулгын өглөгт бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг буюу хүлээн авагчид олгогдоогүй байгаа мөнгөн төлбөрийн үүргийг бүртгэнэ. Цахим мөнгө гаргах-төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий, Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгслийг ойлгоно. Ногдол ашгийн өглөг гэж ногдол ашиг олгохоор зарласны дараа хувьцаа эзэмшигчдэд олгохоор хуваарилж, бүртгэсэн ногдол ашгийг ойлгоно. Санхүүгийн хэрэгсэл нь өр төлбөр ба өмчийн бүрэлдэхүүн хэсгийн аль алиныг агуулж байвал нийлмэл санхүүгийн хэрэгсэл болох ба хувьцаанд хөрвөх

**Санхүүгийн бус өр төлбөрт** цалингийн өглөг, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, тайлант үеийн орлогын албан татварын өглөг, бусад татварын өглөг, хойшлогдсон татварын өглөг, хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц, зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүргийн нөөц, хойшлогдсон орлого, урьдчилж орсон орлого, борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр, тэтгэвэр, тэтгэмжийн сан (өр төлбөр), түрээсийн хойшлогдсон орлого хамрагдана. Хойшлогдсон орлого гэж СТОУС-ын шаардлагын дагуу хүлээн зөвшөөрөлтийг нь хойшлуулсан бөгөөд хараахан орлого гэж тооцоогүй өр төлбөрийг хэлнэ. СТОУС 9-д зааснаар санхүүгийн баталгааны гэрээ гэж өрийн хэрэгслийн анхны буюу өөрчлөгдсөн нөхцөлийн дагуу зээлдэгч нь төлбөрөө хугацаандаа барагдуулаагүйн улмаас үүссэн гарзыг эзэмшигчдэд нөхөн төлөх зорилгоор тодорхой төлбөрийг барагдуулахыг уг хэрэгслийг гаргагчаас шаардаж буй гэрээ бөгөөд тайлангийн өдрөөр санхүүгийн баталгаанд харгалзах нөөцийн дүнг тухайн баталгаатай холбоотой хойшлогдсон шимтгэлийн орлогын дүнтэй харьцуулна. Хэрэв хойшлогдсон орлого нь бага гарвал өр төлбөрийн дүнг шаардлагатай нөөцийн хэмжээ хүртэл нэмэгдүүлнэ. Хэрэв нөөц нь хойшлогдсон орлогын дүнгээс бага байвал нэмж журналын бичилт хийх шаардлагагүй. Өр төлбөрийг төлөх эсхүл төлөгдсөн дүнгээр хэмжиж бүртгэнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн бусад өр төлбөрийг Монголбанкнаас зарласан ханшаар тооцож, төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэх ба ханшийн зөрүүнээс үүссэн өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Мөнгөн бус зүйлсийн өр төлбөрт ханшийн зөрүүний тохируулга хийхгүй.

**Өөрийн хөрөнгө гэж** хөрөнгөөс нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг өмч (өөрийн хөрөнгө) гэнэ. Өмч нь хувь нийлүүлсэн хөрөнгө, нэмж төлөгдсөн капитал, халаасны хувьцаа, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан ашиг, алдагдал, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ

**Хувь нийлүүлсэн хөрөнгө** Хувьцаа эзэмшигчид ТЗЭ-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулна. ТЗЭг нээлттэй хэлбэрээр зохион байгуулсан тохиолдолд үнэт цаас гаргаж нийтэд санал болгох, худалдах ажиллагаа нь Монгол Улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдэх ба нягтлан бодох бүртгэлийг СТОУС, Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж болон энэхүү зааврын дагуу гүйцэтгэнэ. Хувьцаа нь ТЗЭ-ийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байна. Хувьцаа нь энгийн хувьцаа ба давуу эрхийн хувьцаа гэсэн хоёр төрөлтэй байна. Давуу эрхийн хувьцаа нь бусад төрлийн хувьцаа, ялангуяа энгийн хувьцаатай холбоотой зарим нэг давуу эрхийг агуулсан хувьцаа юм. Давуу эрхийн хувьцааны нөхцөлөөс шалтгаалан өмч, эсхүл өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.ТЗЭ нь хувьцаа эзэмшигчдийн

Мэдээлэл Аудит ХХК РД. 2703939

оруулсан хөрөнгийг буцаах үүрэг хүлээхгүй ба ногдол ашгийг төлөхөөс татгалзах эрхтэй тохиолдолд энэхүү давуу эрхтэй хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Хэрэв давуу эрхийн хувьцааг эргүүлэн төлөх буюу ногдол ашгийг заавал төлөх үүрэгтэй бол тухайн хувьцааг санхүүгийн өр төлбөр гэж үзнэ

**Орлогод** орлого болон олз багтана. Орлого гэж өмч эзэмшигчдээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий хөрөнгийн орлогын гүйлгээ буюу сайжруулалт, эсхүл өр төлбөрийн бууралт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм. .Олз гэж үйл ажиллагааны явцад үүсэж болох, орлогын тодорхойлолтод нийцэх бусад зүйлсийг ойлгоно. Тухайлбал, олзонд эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах үеийн олз, хэрэгжсэн ба хэрэгжээгүй олз (гадаад валютын, үнэт цаасны үнэлгээний ба арилжааны гэх мэт) багтана. .Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр юм. Хөрөнгийн өсөлт эсхүл өр төлбөрийн бууралттай холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн нэмэгдэлт үүссэн бөгөөд түүнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан мөнгө эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцож, үнэлнэ. Гэрээний дагуу нэмэлт төлбөр, хойшлогдсон орлого, зардал гараагүй нөхцөлд хүүгийн орлогыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Хямдруулалт, урамшуулал, хойшлуулсан орлого, зардлыг холбогдох санхүүгийн хэрэгслийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хуваарилж, бүртгэнэ. Орлогод хүүгийн орлого, арилжааны орлого, үнэлгээний өөрчлөлтийн олз, хураамж, шимтгэлийн орлого, бусад орлого, олз хамрагдана.

**Зардалд** зардал болон гарз багтана. Зардал гэж өмч эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын гүйлгээ буюу хорогдон багасалт, эсхүл өр төлбөрийн үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн бууралт юм. Гарз гэж ТЗЭ-ийн үйл ажиллагааны явцад үүсэж болох, зардлын тодорхойлолтод нийцэх бусад зүйлсийг ойлгоно. Хүүгийн зардал нь ТЗЭ-ийн үйл ажиллагааны эх үүсвэрт ашиглах зорилгоор бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг байна. Хөрөнгийн бууралт эсхүл өр төлбөрийн өсөлттэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн багасалт үүссэн бөгөөд түүнийг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө. Зардлыг төлсөн мөнгө эсхүл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ. Хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшнээр тооцож үнэлнэ. Татан төвлөрүүлсэн эх үүсвэртэй холбоотой нэмэлт урамшуулал, хямдруулалт, хойшлогдсон орлого болон зардал гараагүй нөхцөлд хүүгийн зардлыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Зардалд хүүгийн зардал, эрсдэлийн сангийн зардал, арилжааны зардал, үнэлгээний өөрчлөлтийн гарз, үйл ажиллагааны бусад зардал хамрагдана.

Мэдээлэл Аудит ХХК РД: 2703939

**ТОДРУУЛГА 3 - Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**

| № | Төрөл | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| 1 | **Бэлэн мөнгө** (1.1+...+1.5) | **54,414,300.14** | **54,414,300.14** |
| 1.1 | Бэлэн мөнгө | | 54,414,300.14 |
| 2 | **Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)** (2.1+...+2.4) | **58,311,486.94** | **47,516,440.93** |
| 2.1 | Дотоодын банканд байршуулсан мөнгө | 58,311,486.94 | 47,516,440.93 |
| **5** | **Дүн (1+2+3+4)** | **58,311,486.94** | **101,930,741.07** |

**ТОДРУУЛГА:4 ЗЭЭЛ**

| № | Төрөл | 2023.12.31 | Олгосон/ Нэмж байгуулсан | Хасагдсан | | | 2024.12.31 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Мөнгөөр/ Зээл | Данснаас хассан/ Сангаас хаасан | Бусад | |
| 1 | Хэвийн | 1,797,833,133.22 | 188,833,735.54 | 285,408,504.41 | | | 1,701,258,364.35 |
| 2 | Анхаарал хандуулах | | | | | | |
| 3 | Хэвийн бус | | | | | | |
| 4 | Эргэлзээтэй | | | | | | |
| 5 | Муу | 117,383,827.90 | | 3,851,030.00 | | | 113,532,797.90 |
| 6 | Зээлийн хойшлогдсон орлого | | | | | | |
| 7 | Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | | 453,513,290.42 | | | | 453,513,290.42 |
| 8 | Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан | 117,383,827.90 | | 3,851,030.00 | | | 113,532,797.90 |
| **9** | **Дүн** | **1,797,833,133.22** | **642,347,025.96** | **285,408,504.41** | | | **2,154,771,654.77** |

**4.1.ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ**

| № | Үнэ цэнэ буурсан хөрөнгө | Хугацаа ндаа байгаа | 30 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн | 31-90 хоногоор хугацаа хэтэрсэн | 91-180 хоногоор хугацаа хэтэрсэн | 181-360 хоногоор хугацаа хэтэрсэн | 361-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 498,835,473.00 | | | | | | 498,835,473.00 |
| 8 | Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан | | | | | | | |
| | **Дүн** | **498,835,473.00** | | | | | | **498,835,473.00** |

Мэдээлэл Аудит ХХК РД: 2703939

ТОДРУУЛГА:8 БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

| № | Төрөл | 2023.12.31 | Нэмэгдсэн | Хасагдсан | | | 2024.12.31 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөгдсөн | Данснаас хассан | Бусад | |
| 1 | Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр) | 521,561,861.06 | 0.00 | 0.00 | 498,835,423.58 | 0.00 | 22,726,437.48 |
| 2 | Бусад | 154,529,632.65 | 0.00 | 0.00 | 154,529,632.65 | 0.00 | 0.00 |
| | **Дүн (1+2+3+4+5)** | **676,091,493.71** | **0.00** | **0.00** | **653,365,056.23** | **0.00** | **22,726,437.48** |

ТОДРУУЛГА:12 БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

| № | Төрөл | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| 1 | Бараа материал | 0.00 | 2,422,232.00 |
| 2 | Урьдчилж төлсөн тооцоо/ зардал | **0.00** | **158,376,230.10** |
| 2.1 | Урьдчилж төлсөн тооцоо | 0.00 | 0.00 |
| 2.2 | Урьдчилж төлсөн зардал | 0.00 | 158,376,230.10 |
| 8 | **Дүн (1+2+3+4+5+6+7)** | **0.00** | **160,798,462.10** |

**ТОДРУУЛГА:18.ТАТВАР, НДШ-ИЙН ӨР ТӨЛБӨР**

| № | Ангилал | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| 1 | Татварын өглөг | **2,340,660.34** | **14,393,345.98** |
| 1.3 | ХАОАТ-ын тооцоо | 2,340,660.34 | 4,893,345.98 |
| 1.4 | Бусад татварын өглөг | | 9,500,000.00 |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг | 6,962,947.02 | |
| 3 | Дүн | **9,303,607.36** | **14,393,345.98** |

**20.1.ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ**

| № | Үзүүлэлт | 2023.12.31 | Нэмэгдсэн | Хасагдсан | 2024.12.31 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө) | | | | |
| 2 | Энгийн хувьцаа - Хаалттай | 2,652,000,000.00 | 0.00 | 0.00 | 2,652,000,000.00 |
| 3 | Энгийн хувьцаа - Нээлттэй | | | | |
| **6** | **Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн (1+2+3+4+5)** | 2,652,000,000.00 | 0.00 | 0.00 | 2,652,000,000.00 |

**ТОДРУУЛГА:21.ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ**

| № | Үзүүлэлт | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| 1 | Зээлийн эрсдэлийн сангийн зардал | 16,976,083.92 | 0.00 |
| | **Дүн** | **16,976,083.92** | **0.00** |

Мэдээлэл Аудит ХХК РД: 2703939

## ТОДРУУЛГА: 24.ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ

| № | Үзүүлэлт | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| 3 | **Үйлчилгээний хураамж, шимтгэлийн зардал** | **0.00** | **3,027,700.00** |
| 3.1 | Зээлийн хураамж, шимтгэлийн зардал | 0.00 | 0.00 |
| 3.2 | Банкны шимтгэлийн зардал | | 327,700.00 |
| 3.3 | Бусад үйлчилгээний зардал | | 2,700,000.00 |
| 4 | **Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардлын дүн** | **228,413,106.70** | **187,209,302.00** |
| 4.1 | Цалингийн зардал | 127,592,516.73 | 124,178,473.56 |
| 4.2 | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал | 15,923,512.87 | 33,254,256.06 |
| 4.3 | Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал | 0.00 | 1,378,000.00 |
| 4.4 | Зарлал, сурталчилгаа, маркетингийн зардал | 6,310.00 | 0.00 |
| 4.5 | Элэгдэл, хорогдлын зардал | 14,702,365.20 | 0.00 |
| 4.6 | Түрээсийн зардал | 40,052,000.00 | 4,775,800.00 |
| 4.7 | Ашиглалтын зардал | 15,987,953.90 | 8,654,953.00 |
| 4.8 | Харилцаа холбооны зардал | 13,073,368.00 | 10,128,815.00 |
| 4.9 | Түлш шатахуун, тээврийн зардал | 378,180.00 | 925,000.00 |
| 4.10 | Үйл ажиллагааны бусад зардал | 696,900.00 | 3,914,004.38 |
| 5 | **Дүн** | **228,413,106.70** | **190,237,002.00** |

## ТОДРУУЛГА: 25. БУСАД ЗАРДАЛ, ГАРЗ

| № | Зардлын төрөл | Өмнөх оны дүн | Тайлант оны дүн |
|---|---|---|---|
| 1 | Зочин төлөөлөгч, баяр ёслолын зардал | 6,574,643.00 | 3,362,380.00 |
| 2 | Хандив | | 20,000,000.00 |
| 3 | Торгууль | | 398,700.00 |
| 10 | **Бусад зардал, гарзын дүн** | **6,574,643.00** | **23,761,080.00** |

Мэдээлэл Аудит ХХК РД: 2703939

## ТОДРУУЛГА:27.ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

### 27.1.ТОЛГОЙ КОМПАНИ, ХАМГИЙН ДЭЭД ХЯНАЛТ ТАВИГЧ КОМПАНИ, ХУВЬ ХҮНИЙ ТАЛААРХ

| № | Үзүүлэлт | Толгой компани | Хамгийн дээд хяналт тавигч толгой компани | Хамгийн дээд хяналт тавигч хувь хүн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэр | Милленниум групп ХХК | | Э.Батшугар | |
| 2 | Бүртгэгдсэн /оршин суугаа/ улс | Монгол | | Монгол | |
| 3 | Эзэмшлийн хувь | 100 | | 100 | |

### 27.3.ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

| № | Холбоотой талын нэр | Ажил гүйлгээний утга | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Милленниум групп ХХК | Ноогдол ашгийн өр төлбөр | -10,000,000.00 | 2022 онд заралсан ноогдол ашиг өр төлбөрөөс |
| 2 | Милленниум групп ХХК | Түрээсмйн төлбөр төлөв | -4,000,000.00 | Оффис түрээсийн гэрээний дагуу |
| 3 | Милленниум групп ХХК | Түрээсийн зээл авав | 8,899,900.00 | Бэлэн мөнгөний эргэлтгүй илмаас цалинд зориулж |
| 4 | Милленниум групп ХХК | Түр зээл хаав | -8,899,900.00 | Дээрх өрөө барагдуулав |
| 5 | Монфарм трейд ХХК | Хуримтлагдсан хүүгийн авлага | 1,408,375.50 | Зээлийн хуримтлагдсан хүү төлөв |
| 6 | Монфарм трейд ХХК | Нэмж зээл олгов | -5,000,000.00 | 2024.02.21 Шинээр зээл олгов |
| 7 | Монфарм трейд ХХК | Үндсэн зээлийн төлөлт | 965,193.37 | 2024.02.29 өмнөх зээлийн үндсэн зээлийн төлөлт |
| 8 | Монфарм трейд ХХК | Зээлийн хүүгийн орлого | 483,065.95 | 2024.02.29 Тайлант хугацааны хүүгийн төлөлт |
| | | | **16,143,365.18** | |

Мэдээлэл Аудит ХХК РД: 2703939